

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2024/07/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Говьсүмбэр аймаг 2024 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179, Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: "Платиниум прогресс аудит" ХХК Захирал: Ж.Баяртуул Утас: 99066015, Цахим хаяг: platinumprogressaudit@gmail.com Аудитор: Б.Дэлгэрмаа Утас: 90109012, Цахим хаяг: platinumprogressaudit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govissumber@audit.gov.mn

2024.02.22 № 03

танай _____ -ны № _____ -г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн "Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар"-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн "Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар"-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

008020006

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 92.арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 88.8 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>13,764,152.00</u>	<u>19,719,836.80</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,913,898.00	11,308,574.97
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,913,898.00	11,308,574.97
3121	Төгрөг	6,913,898.00	11,308,574.97
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	6,913,898.00	11,308,574.97
33	АВЛАГА	-	861,007.83
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	861,007.83
35	БАРАА МАТЕРИАЛ	6,850,254.00	7,550,254.00
354	Хангамжийн материал	6,850,254.00	7,550,254.00
35420	Аж ахуйн материал	6,850,254.00	7,550,254.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>71,582,542.67</u>	<u>69,849,557.46</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	71,582,542.67	69,849,557.46
392	Биет хөрөнгө	53,371,167.59	51,076,057.34
39203	Авто-тээврийн хэрэгсэл	18,500,000.00	18,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(11,562,499.80)	(14,645,833.08)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	38,088,040.00	48,128,580.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(17,642,088.02)	(23,804,509.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,443,448.00	38,574,448.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,940,132.51)	(19,269,006.05)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,474,000.00	8,174,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,989,600.08)	(4,581,622.32)
393	Биет бус хөрөнгө	18,211,375.08	18,773,500.12
39301	Програм хангамж	2,089,000.00	1,301,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,877,624.92)	(527,999.88)
39303	Бусад биет бус хөрөнгө	18,000,000.00	18,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>85,346,694.67</u>	<u>89,569,394.26</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>22,549.70</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	22,549.70
413	Өглөг	-	22,549.70
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	20,734.53
4136	Бусад өглөг	-	1,815.17
41361	Байгууллагад төлөх өглөг	-	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	1,815.17
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>85,346,694.67</u>	<u>89,546,844.56</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	85,346,694.67	89,546,844.56
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	83,558,561.82	83,558,561.82
51101	Өмч: - төрийн	83,558,561.82	83,558,561.82

512	Хуримтлагдсан үр дүн	(17,835,167.15)	(13,635,017.26)
51210	Өмнөх үеийн үр дүн	(99,730,333.82)	(17,835,167.15)
51220	Тайлант үеийн үр дүн	81,895,166.67	4,200,149.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	19,623,300.00	19,623,300.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>85,346,694.67</u>	<u>89,569,394.26</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	383,746,043.78	519,817,349.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	100,400,496.78	27,259,229.00
120	Нийтлэг татварын бус орлого	100,400,496.78	27,259,229.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,400,496.78	27,259,229.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	8,944,659.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	100,400,496.78	18,314,570.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	283,345,547.00	492,558,120.59
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	263,168,600.00	449,400,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	263,168,600.00	449,400,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,176,947.00	43,158,120.59
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,500,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,646,000.00	18,318,472.59
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,630,947.00	24,839,648.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,400,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	301,850,877.11	517,230,069.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	301,850,877.11	517,230,069.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	291,066,692.43	480,325,371.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	143,708,658.89	268,867,527.94
210101	Үндсэн цалин	115,719,591.99	182,631,242.18
210102	Нэмэгдэл	15,315,885.91	47,415,318.96

210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,308,999.39	24,370,000.00
210104	Урамшуулал	6,364,181.60	14,450,966.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,385,834.44	34,095,802.67
210201	Тэтгэврийн даатгал	14,078,744.86	23,823,452.81
210202	Тэтгэмжийн даатгал	1,253,939.23	2,843,586.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	932,591.45	2,093,081.00
210204	Ажилгүйдлийн даатгал	192,778.60	461,127.08
210205	Эрүүл мэндийн даатгал	1,927,780.30	4,874,555.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,460,913.79	20,786,656.70
210301	Гэрэл, цахилгаан	848,052.79	1,524,610.40
210302	Түлш, халаалт	18,600,523.00	18,158,744.30
210303	Цэвэр, бохир ус	1,012,338.00	1,103,302.00
2104	Хангамж, бараа материалын зардал	58,216,942.00	68,653,369.20
210401	Бичиг хэрэг	18,686,100.00	17,755,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,977,630.00	4,974,730.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,163,586.00	702,960.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	140,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	8,829,050.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	33,149,626.00	36,178,479.20
210408	Бараа материал акталсны зардал	-	72,450.00
2105	Нормативт зардал	4,269,659.00	6,232,809.13
210502	Хоол, хүнс	4,269,659.00	6,232,809.13
2107	Томилолт, зочны зардал	590,000.00	192,000.00
210702	Дотоод албан томилолт	590,000.00	192,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,560,763.20	57,884,181.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,962,817.20	56,134,835.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	655,500.00	1,079,200.00

210803	Даатгалын үйлчилгээ	504,300.00	247,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	41,046.00	48,646.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	14,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	360,000.00
210807	Газрын төлбөр	15,100.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,873,921.11	23,613,025.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	770,000.00	3,050,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,088,000.00	566,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,015,921.11	19,997,025.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,784,184.68	36,904,697.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,250,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,784,184.68	35,654,697.85
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,784,184.68	35,654,697.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>81,895,166.67</u>	<u>2,587,279.89</u>
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	1,612,870.00
140020	Дансны орлого		1,612,870.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	1,612,870.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>81,895,166.67</u>	<u>4,200,149.89</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<u>290,259,445.00</u>	<u>501,502,779.59</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>6,913,898.00</u>	<u>8,944,659.00</u>
120	Нийтлэг татварын бус орлого	6,913,898.00	8,944,659.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,913,898.00	8,944,659.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,913,898.00	8,944,659.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>283,345,547.00</u>	<u>492,558,120.59</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	263,168,600.00	449,400,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	263,168,600.00	449,400,000.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,176,947.00	43,158,120.59
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,500,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,646,000.00	18,318,472.59
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,630,947.00	24,839,648.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,400,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	<u>283,533,863.00</u>	<u>498,720,972.62</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>283,533,863.00</u>	<u>498,720,972.62</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>272,749,678.32</u>	<u>461,816,274.77</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	148,403,932.89	269,638,434.69
210101	Үндсэн цалин	120,414,865.99	180,814,671.65
210102	Нэмэгдэл	15,315,885.91	50,205,692.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,308,999.39	24,360,000.00
210104	Урамшуулал	6,364,181.60	14,258,070.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,385,839.44	34,163,354.05
210201	Тэтгэврийн даатгал	13,058,855.81	23,931,521.09
210202	Тэтгэмжийн даатгал	1,536,335.73	2,805,085.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,158,508.69	2,093,081.10
210204	Ажилгүйдлийн даатгал	239,285.41	459,109.92
210205	Эрүүл мэндийн даатгал	2,392,853.80	4,874,556.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,460,913.79	20,786,656.70
210301	Гэрэл, цахилгаан	848,052.79	1,510,144.41
210302	Түлш, халаалт	18,486,761.00	18,173,210.29
210303	Цэвэр, бохир ус	1,126,100.00	1,103,302.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,572,299.00	1,252,600.00
210401	Бичиг хэрэг	723,700.00	167,500.00
210402	Тээвэр, шатахуун	945,013.00	609,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,163,586.00	335,400.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	140,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	-
2105	Нормативт зардал	2,500,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	160,200.00	78,500.00
210604	Урсгал засвар	160,200.00	78,500.00
2107	Томилолт, зочны зардал	590,000.00	302,000.00
210702	Дотоод албан томилолт	590,000.00	302,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	73,404,514.20	130,144,397.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,806,568.20	129,336,651.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	655,500.00	321,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	504,300.00	247,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	41,046.00	48,646.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	14,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	176,400.00
210807	Газрын төлбөр	15,100.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,271,979.00	5,450,332.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,232,909.00	4,549,982.03
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,039,070.00	900,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,784,184.68	36,904,697.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,250,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,784,184.68	35,654,697.85
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,784,184.68	35,654,697.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>6,725,582.00</u>	<u>2,781,806.97</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	1,612,870.00
140020	Дансны орлого		1,612,870.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,044,593.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,044,593.00	-

2200	Дотоод эх үүсвэрээр	1,044,593.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,044,593.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,044,593.00)	1,612,870.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	5,680,989.00	4,394,676.97
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,451,528.00	6,913,898.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,913,898.00	11,308,574.97

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	83,558,561.82	19,749,077.00	- 24,735,746.04	78,571,892.78
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	- 74,994,587.78	-74,994,587.78
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	83,558,561.82	19,749,077.00	- 99,730,333.82	3,577,305.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	-125,777.00	0.00	-125,777.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	81,895,166.67	81,895,166.67
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	83,558,561.82	19,623,300.00	- 17,835,167.15	85,346,694.67
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	83,558,561.82	19,623,300.00	- 17,835,167.15	85,346,694.67
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	83,558,561.82	19,623,300.00	- 17,835,167.15	85,346,694.67
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	4,200,149.89	4,200,149.89
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	83,558,561.82	19,623,300.00	- 13,635,017.26	89,546,844.56

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	449,401,300.00	413,846,975.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	449,401,300.00	413,846,975.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	447,901,300.00	412,596,975.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	298,155,300.00	266,499,189.01
210101	Үндсэн цалин	168,875,400.00	180,814,671.65
210102	Нэмэгдэл	88,474,700.00	47,066,446.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,970,000.00	24,360,000.00
210104	Урамшуулал	15,835,200.00	14,258,070.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,270,300.00	33,671,627.14
210201	Тэтгэврийн даатгал	25,343,200.00	23,568,895.51
210202	Тэтгэмжийн даатгал	2,981,600.00	2,772,810.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,385,200.00	2,067,260.74
210204	Ажилгүйдлийн даатгал	596,300.00	452,655.08
210205	Эрүүл мэндийн даатгал	5,964,000.00	4,810,004.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,808,800.00	20,786,656.70
210301	Гэрэл, цахилгаан	1,510,700.00	1,510,144.41
210302	Түлш, халаалт	18,194,300.00	18,173,210.29
210303	Цэвэр, бохир ус	1,103,800.00	1,103,302.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,260,600.00	1,252,600.00
210401	Бичиг хэрэг	167,500.00	167,500.00
210402	Тээвэр, шатахуун	610,600.00	609,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	335,400.00	335,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	147,100.00	140,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	78,500.00	78,500.00

210604	Урсгал засвар	78,500.00	78,500.00
2107	Томилолт, зочны зардал	302,200.00	302,000.00
210702	Дотоод албан томилолт	302,200.00	302,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	89,124,300.00	89,106,052.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	88,308,400.00	88,298,306.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	321,200.00	321,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	247,100.00	247,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,400.00	48,646.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14,400.00	14,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	176,400.00	176,400.00
210807	Газрын төлбөр	7,400.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	901,300.00	900,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	901,300.00	900,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00	1,250,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,250,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	449,400,000.00	449,400,000.00
1320	УЛСЫН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	449,400,000.00	449,400,000.00
122005	Улсын нутгийн төсвөөс	449,400,000.00	449,400,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	44,770,990.59
21.00	УРСГАЛ ЗАРДАЛ	44,669,317.59
210.00	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,669,317.59
2,101.00	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,139,245.68
210,102.00	Нэмэгдэл	3,139,245.68
2,102.00	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	491,726.91

210,201.00	Тэтгэврийн даатгал	362,625.58
210,202.00	Тэтгэмжийн даатгал	32,274.71
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	25,820.36
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	6,454.84
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	64,551.42
2,108.00	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,038,345.00
210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,038,345.00
2,133.00	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	101,673.00
213,303.00	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	101,673.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	44,770,990.59
1,311.00	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,770,990.59
131,103.00	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,318,472.59
131,104.00	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,839,648.00
140,020.00	Дансны орлого	1,612,870.00

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулж, дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг 2022 оны аудитлагдсан санхүүгийн тайлантай тулган шалгахад зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3 дэх “*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*” гэсэн заалтыг зөрчсөн ба толилуулга, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Санхүүгийн тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн 20,734.5 төгрөгийн өглөгийг тусгаагүй алдаа илэрсэн бөгөөд энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.7 дахь “*аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах*” гэсэн заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 19,440.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 2,181.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 14,243.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 3,015.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Байгууллагын даргын 2023 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн Б/07 дугаар тушаалаар 2022 оны аудитын дүгнэлтээр зөрчилгүй дүгнэлтийг аудитын байгууллагаас авсан гэх үндэслэлээр нягтлан бодогчоор ажиллаж байсан Б.Мэндбаярт урамшууллыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Төрийн албаны тухай хуулийн 51.1.4 дэх “*Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох*”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2 дахь “*Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна.*”, Сангийн сайдын 2022 оны 28 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 25 дахь заалтуудыг тус тус зөрчсөн ба “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Хууль журмыг зөрчин олгосон урамшууллыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.2 Сахилгын шийтгэл оногдуулсан 1 ажилтанд сахилгын шийтгэл тооцсоноос хойш урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 48.7-д *"Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно."*, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.7-д *"Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй."* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

3.2.1 Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд 5,922,000.0 төгрөгийн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн хуулбарын 32 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4 *"Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ"*, 6.4.8 *"бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"* гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3.2.2 Тайлант онд сургалт, зөвлөгөөн, бусад үйл ажиллагаа зохион байгуулахдаа хоол, бэлэг дурсгалын зүйлд төсөв зарцуулж төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.5 дэх *"төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"*; 15.2.3 дахь *"сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх"* гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид анхаарч ажиллах албан шаардлага өгөв.

3.3 Зөвлөмж

3.3.1. Урамшуулалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт Тайланд онд ЗГ-ын 2023.12.27-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийн дагуу албан хаагчдад цалингийн урамшууллыг олгохдоо ажилласан цаг хугацаа болон ажлын үр дүнг харгалзалгүйгээр нийтэд нь хавтгайруулан олгосон байна. Тухайлбал 2023 оны сүүлийн 2 сар ажилласан 3 ажилтанд 100.0 хувиар урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 46.3.2. *"байгууллагын хамт олон, ажилтныг ажлын үр дүнг нь харгалзан урамшуулах"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид анхаарч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайлан өмнөх оны аудитлагдсан тайлангаас зөрүүтэй	1	0.0			1	0.0	1	0.0				
Санхүүгийн тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг тусгаагүй	1	20.7	1	20.7			1	20.7				
Дүн	2	20.7	1	20.7	1	0.0	1	20.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн сангаас урамшуулал давхардуулан олгосон.	1	861.5	1	861.5								
Сахилгын шийтгэлтэй ажилтанд урамшуулал олгосон.	1	1,320.0	1	1,320.0								
Цалингийн урамшууллыг хавтгайруулан олгосон.	1	3,015.0					1	3,015.0				
Дүн	3	5,196.5	2	2,181.5			1	3,015.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн хуулбарын 32 мэдээллийг байршуулаагүй.	1	5,922.0			1	5,922.0		
Дүн	1	5,922.0			1	5,922.0		
Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Сургалт, зөвлөгөөн, бусад үйл ажиллагаа зохион байгуулахдаа хоол, бэлэг дурсгалын зүйлд төсөв зарцуулж төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан.	1	8,321.5			1	8,321.5		
Дүн	1	8,321.5			1	8,321.5		
Нийт дүн	2	14,243.5			2	14,243.5		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			